



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 113

Эрдэнэт

Нийтлэг үйлчилгээний алба байгуулах,
дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "ж", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийг шинэчлэн баталсантай холбогдуулан "Нийтлэг үйлчилгээний алба" Улсын төсөвт үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулсугай.

2. Нийтлэг үйлчилгээний албаны дүрмийг нэгдүгээр хавсралтын ёсоор, бүтцийг хоёрдугаар хавсралтын ёсоор, орон тоог гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Нийтлэг үйлчилгээний албаны хэвийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.



ДАРГА  Д.БҮРЭВЛХАГВА